



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар A/654

Хэрлэн сум

Төсөл арга хэмжээний худалдан
авах ажиллагаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралт Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны "Эрх шилжүүлэх тухай" 267 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасан XII.1.127 дугаартай "Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал, Батноров сум, Бэрх тосгон)" төсөл арга хэмжээний багцуудыг хавсралтаар байгуулсугай

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 2 дугаар сарын 24-ний "Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах тухай" А/98 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022
оны 12 дугаар сарын 21-ны
дугаар захирамжийн хавсралт

| Багцын дугаар | Багцын нэр | Төсөвт өртөг (төгрөг) | 2022 оны санхүүжилт (төгрөг) |
|---------------|--|-----------------------|------------------------------|
| Багц 1 | Сумын төвийн цэвэр усны хангамжийн байгууламж (Хэнтий, Баянхутаг сум), Усан хангамжийн байгууламж, шугам сүлжээ (Хэнтий, Дэлгэрхаан сум), Усан хангамжийн байгууламж, шугам сүлжээ (Хэнтий, Мөрөн сум) | 1 088 000 000 | 448 200 000 |
| Багц 2 | Сумын төвийн усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Баян-Адарга сум), Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Норовлин сум), Цэвэрлэх байгууламж (Хэнтий, Цэнхэрмандал сум) | 5 972 800 000 | 2 459 700 000 |
| Багц 3 | Сумын төвийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Баян-Овоо сум), Сумын төвийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Дадал сум) | 1 776 704 250 | 731 500 000 |
| Багц 4 | Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон) | 2 225 895 750 | 916 800 000 |